

ШИШЭ НОРЬШ МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ



2007/12 сар №03

Редактор: Ч.Гульнар
Эмхэтгэсэн: Ж.Баатарсүрэн
Д.Даваамандах
Ч.Хишигсүрэн

Манай хаяг:
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу, 8-р хороо ШУТИС-ийн 1-р
байр
Утас: 314029, 324590 - 1026, 1027, 1034
Майл: librar@must.edu.mn



ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛЬ
ТӨВЛӨРСӨН НОМЫН САН

Энэ дугаарт



2007 оны 12 сард ирсэн шинэ номын мэдээ	...1-19
Төвлөрсөн номын санд ном хандивлав	...20-23
2007 оны номын төвлөрлийн тооцоо	...24
2007 оны фонд бүрдүүлэлт	...25
Номын өдөрлөг болов	...26
Монгол Улсын Шинжлэх Ухаан, Технологийн Е-номын сан семинар болов	...27
ОХУ-ын шинжлэх ухааны е-номын сан	...28
Төв номын сангийн хэвлэл захиалга	...29-31
Төв номын сангийн 12 сарын үйлчилгээний байдал	...32-33

Улаанбаатар хот
2007

Төв номын сан 12 сард 25 гаруй нэр төрлийн 193 ширхэг ном, сурах бичиг авсан. Үүнд:

Нийгэм, улс төр, эдийн засаг, түүхийн чиглэлээр



Батбаяр Б.
Үйлдвэрийн эдийн засгийн онол / Ред. Д. Болдбаатар.- УБ., 2007.-274 х. - ISBN 978-99929-0-261-2 (5000)

Үйлдвэрийн газруудын зайлшгүй эдийн засгийн гол асуудлыг онол, практик, дэлхийн улс үндэстнүүдийн хэрэглэж, ашиглаж байгаа сэдвүүд болон үйлдвэрийн эдийн засгийн тухай үндсэн ойлголт, үйлдвэрийн менежмент, үйлдвэрлэлийн процессын талаар т у с г а ж э э .

Батбаяр Б.
Дэлхийн эдийн засаг.- УБ., 2007.- 211 х. - ISBN 978-99929-0-262-2
 ()

Энэхүү сурах бичигт дэлхийн эдийн засаг, дэлхийн зах зээлийн тухай тодорхойлолтууд, тэдгээрийн ялгаатай тал, нөөц баялагийн байршил, тэдгээрийн хуваарилалт, олон улсын байгуулагууд, хөгжиж буй орнуудын дэлхий эдийн засагт эзлэж буй байр суурь, тэдгээрийн өөрчлөлтийн хандлага зэрэг олон асуудлыг тусгажээ.






Батбаяр Б.
Эдийн засгийн онолын үндсэн хичээлийн гарын авлага: Сорил тест бодлого дасгал.- УБ.: “Жасби” ХХК., 2007.- 216 х. -ISBN 978-99929-05-272 ()

Энэхү номд эдийн засгийн онол, олон улсын санхүү, макро микро эдийн засгийн талаарх тест бодлогуудыг оруулжээ.

Nenry Minrzbeg, Bruce Ahlstrand, Joseph Lampel

Стратегийн эрэлд: Стратегийн онгон зэлүүд талаар тайлбарлуулан аялах нь / Орч. Д. Одмаа; Ред. Ш. Чуданжий, Д. Давгадорж.- УБ.: Адмон, 2005.-355 х. .- ISBN 99929-0-432-1 ()

Стратегийн менежментийн хөгжил, урьд өмнө нь дэлхийн менежментийн шилдэг эрдэмтэн судлаачдын бичсэн голлох бүтээлүүдийг урсгал чиглэл бүрээр нь дэлгэрэнгүй өгүүлээд менежментийн мөн чанарыг ойлгомжтой тайлбарласан байна.





Давгадорж Д.
Маркетинг: Зах зээлийг жолоодох түлхүүр ухаан.- УБ.: Адмон, 2006.- 144 х. –ISBN 99929-0-046-6 ()

Маркетингийн ухаанаар зах зээлийг эзэмдэх улмаар удирдан жолоодох арга ухааны талаар энэхүү номд өгүүлжээ.

Давгадорж Д.
Маркетингийн судалгаа / Ред. Г. Элдэв-Очир.- УБ., 2007.-216 х. ()

Маркетингийн судалгааны арга зүйг шууд эзэмших, ашиглах, бие даасан бүтээлч эрэл, хайгуул хийж амжилт олох түлхүүр, асуудлуудыг багтаасан. 12 бүлэг, 35 зүйлтэй.





Молломжамц Д.

Хөрөнгө оруулалтын эдийн засгийн шинжилгээ / Ред. Хирохико Секияя.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2007.- 202 х. – ISBN 978-99929-53-25- X ()

Хөрөнгө оруулалтын мөн чанар, ангилал, бүтэц ба ач холбогдол, үр ашгийн үнэлгээ, макро эдийн засгийн үзүүлэлт, үр ашигт нөлөөлсөн хөрөнгө оруулалт ба инновацийн төслийн шинжилгээний талаар энэхүү номд тусгажээ.

Молломжамц Д.

Инновацийн эдийн засгийн үр ашгийн шинжилгээ / Ред. Ц. Аюурзана.- УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2007.- 202 х. – ISBN 978-99929-53-21- 7 ()

Энэхүү ном нь инновацийн тухай үндсэн ойлголт; макро эдийн засаг дахь инновацийн бодлого, зохицуулалт; аж ахуйн нэгжийн түвшин дэх инновацийн төслүүдийн сонголт ба үнэлгээ; гадаадын улс орнуудын инновацийн үйл ажиллагааны онцлог; инновац ба хөрөнгө оруулалтын төслийн үр ашгийн шинжилгээ гэсэн 5 бүлгээс бүрдэнэ.






Энхбаатар Ц., Даваахүү Ш.
Бизнесийн харилцаа /
Ред. Х. Нялхай.- УБ., 2006.-166 х. –
ISBN 99929-3-050-0

Энэхүү гарын авлагад бизнесийн харилцаанд тохиолдох үйл ажиллагааны бүхий л талуудыг эх орны ба гадаад орнуудын жишээн дээр тулгуурлан оюутан ба бусад хэрэглэгчдэд ойлгогжтойгоор т у с г а ж э э .

Гунгаанямбуу Ц.
Санхүүгийн бүртгэл,
шинжилгээ, аудит: Сурах бичиг /
Ред. Б. Сайнжаргал.- УБ., 2007.-
175 х.

Энэхүү сурах бичигт нягтлан бодох бүртгэл, данс, санхүүгийн тайлангийн үндсэн ойлголт, санхүүгийн тайлангийн судалгааны аргазүй, аудитын үүсэл хөгжлийн талаар тусгажээ. Номын төгсгөлд нэр томъёоны тайлбартоль, индексийг оруулсан болно.





**Жамбалсүрэн Ц.
Ю. Цэдэнбал: Эрин зууны түүхэн
элч / Ред. Ч. Авдай, Т. Дорж, Д.
Рийзэн, З. Лонжид, Ц. Нүүдэл, Н.
Алимаа.- УБ.: Адмон, 2007.-650 х.
– ISBN 99929-0-242-6**

Монголын нам, засаг төрийн жолоог 44 жил атган барьсан хувь заяатай түүхэн зүтгэлтний амьдрал, тэмцлийн утга агуулга, XX зууны Монголын ээдрээ, зөрчилтэй түүхийн үнэний талаар энэхүү номд тусгажээ.

**Шаравпилжээ Ш.
Монгол ёс жудгаа
хүндэтгэе / Ред. Б.
Чулуунбаатар.- УБ., 2007.- 154 х.**

Зохиогч өөрийн амьдралдаа үзсэн сонсон зүйлийнхээ ухаарал бодлын эрэгцүүллийг шүлэглэн өгүүлжээ.



Техник, технологийн чиглэлээр

Даваадорж Д.
Инженерийн материалын шинж чанар, хэрэглээ: Сурах бичиг / Ред. Т. Минжүүр, Ч. Цэсэндорж.- УБ., 2007.- 217 х. – ISBN 99929-91-01-2

Энэхүү сурах бичигт полимер, композит, пластик, шилэн пластик, шилэн талст, органик ба органик биш шил, наагч болон битүүмжлэгч, резин, керамик, мод зэрэг хийцийн материалын механик шинж, хэрэглээний талаар нилээд дэлгэрэнгүй багтаажээ.

Эконометрийн арга загварууд: Онол, арга загвар хэрэглээ бодлого: Гарын авлага / Я. Базарсад, М. Банзрагч, В. Батзориг, П. Доржнاران, У. Дэлгэрсайхан ба бус. – УБ., 2007.- 226 х.- ISBN 99927-73-132-1

Гарын авлагад шугаман регрессийн загварын параметруудийн үнэлэлт байгуулах хамгийн бага квадратын ба хамгийн их үнэний хувь бүхий арга тэдгээрийн өргөтгөлүүд, авторегрессийн процесс, шугаман загвараар прогноз хийх, регрессийн тэгшитгэлийн системийн загвар, хугацааны стационар болон стационар биш цувааны загварын онцлог зэрэг асуудлыг оруулжээ.





Насанжаргал Д.

Компьютер засвар:

Сонирхогчдод тусламж / Ред. Д.

Ганзориг.- УБ.: Адмон, 2007.-

ISBN 978-99929-0-297-3

Компьютерийн тоног төхөөрөмжүүдийн бүтэц, дотоод сүлжээ, компьютерийн програмын алдаанууд, хэрэггүй мэдээллийг устгах, цэгцлэх талаар тусгажээ.

**Дэнсмаа Ц., Лхамсүрэн Д.,
Өлзийбямба Н.**

Эсгий бүтээгдэхүүн

**үйлдвэрлэх технологи, тоног
төхөөрөмж / Ред. С. Лхамжав.- УБ.:
“Об капитал” хэвлэх үйлдвэр,
2007.- 291 х. – ISBN 978-99929-827-
0-5**

Эсгий эдлэлийн үйлдвэрлэлийг жинхэнэ ёсоор нь зохион байгуулахад шаардагдах тоног төхөөрөмж, баримтлах технологи, ажлын арга барил, анхаарах бодит нөхцлүүдийн талаар үйлдвэр эрхлэгчид, үйлдвэрлэлийн чиглэлээр суралцаж байгаа оюутан, суралцагчдад зориулж бичжээ.





Авдай Ч., Энхтуяа Д.
Судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх арга зүй:
Статистик боловсруулалт, математик загварчлал, оновчлол
 / Ред. Ч. Авдай.-Нэмж засв. 2 дахь хэвл.-УБ., 2007.- 368 х. – ISBN 978-99929-844-1-4 ()


Энэхүү сурах бичигт судалгаа шинжилгээний ажил гэж юу болох, түүнийг хэрэгжүүлэх арга, дэс дараалал, үр дүнг боловсруулан үнэлэлт дүгнэлт өгөх, үр дүнгийн тайланг хэрхэн бичих тухай о р у у л ж э э .

Алтансүх Д. ба бус.
Инженерийн дүрслэх геометр: Сурах бичиг / Д. Алтансүх, М. Цэцгээ, Ж. Цэрэнчунт
 / Ред. Ш. Цэвээндорж.-Нэмж засв. 2 дахь хэвл.-УБ., 2007.- 236 х. . – 978-99929-51-33-8 ()

Энэхүү сурах бичиг нь нэгдсэн ортогональ проекц загварт геометр дүрсийн байршил, хэмжээг тодорхойлох; проекц хувиргах арга; муруй шугам; гадаргуу; гадаргуугийн үндсэн бодлогуудыг бодох; дэлгээс; гадаргууд шүргэгч хавтгай; аксонометр дүрслэл; инженерийн зураг төсөл боловсруулахад CAD систем ашиглах гэсэн 11 хэсгээс бүрдэнэ.



Хэл шинжлэлийн талаар




**Санжаасүрэн Р., Нордов Э.,
Жамъяансүрэн С.**
Англи- монгол толь:
Цемент, бетоны хими, технологи /
Ред. Ц. Эрдэнэбат.- УБ.: МУИС-
ийн хэвлэх үйлдвэр, 2007.- 552 х.
–ISBN 978-99929-53-34-9 ()

Энэхүү толинд нийт 19 мянга шахам мэргэжлийн англи үг, нэр томъёог монгол хэлнээ орчуулан тусгасан бөгөөд олон утгатай англи үгийг орчуулахдаа чухамдаа цемент, бетоны хими, технологид ямар утгаар голлон хэрэглэгддэг болохыг онцлон анхаарчээ.

Баярмөнх Ц.
IBT TOEFL-ийн
шалгалтанд хэрхэн амжилттай
бэлтгэх вэ? .- УБ.: “MN
Технологи ХХК, 2007.- 494 х. +
CD ()

Энэхүү сурах бичиг нь IBT TOEFL-ийн олон арван асуултууд болон эссений сэдвүүд, сонсох болон унших хэсгийн даалгаварууд, тэдгээрт хариулах зөвлөмж, англи хэлээр эссе хэрхэн бичих тухай, яриа болон бичгийн хэсгийн талаар тодорхой бичжээ. Мөн сонсголын болон ярианы хэсгийн загвар хариулт бүхий аудио CD дагалдаж байна.






Болдбаатар Д.
English – Mongolian
dictionary = Англи – Монгол толь
бичиг / Н. Энхбаяр.- УБ.: Бэмби
сан, 2007.- 1215 х. – ISBN 978-
99929-50-32-3 ()

Тус толь бичгийн онцлог нь ярианы болон бичгийн хэлний түгээмэл хэрэглэгддэг үгнүүдээс гадна улс төр, эдийн засаг, шинжлэх ухаан техникийн янз бүрийн салбарын нэр томъёонуудыг түлхүү оруулж, холбогдох жишээнүүдээр б а я ж у у л ж э э .

Болдбаатар Д.
Монгол- Япон толь
бичиг / М. Шагдарсүрэн, С.
Туяагэрэл.- УБ., 2007.-846 х. –
ISBN 978-99929-50-90-0 ()

Орчин цагийн монгол хэлийг гол болгосон энэхүү толь бичиг нь толгой үг болон хоршоо үгс зэргийг оролцуулаад 30 000 гаруй үгийг багтаасан бөгөөд монгол япон хэл дээрх ном сонин сэтгүүл зэргээс сүүлийн үед өргөн хэрэглэгдэх болсон шинэ үг хэллэгүүдийг оруулсан.





Дашдондов Ц., Наранхүү Х.
Монгол англи ижил үгийн
шинэ тайлбар толь / Ред. Б.
Ганболд.- УБ.: Мөнхийн үсэг,
2007.- 342 х. – ISBN 99929-146-8 ()

Хэл эзэмшихэд хамгийн хүндрэлтэй зүйлүүдийн нэг нь ив ижил дуудагдаж, адил дуудагддаг хэрнээ илэрхийлэх утга нь эрс ондоо олон үг байдаг. Ижил үгийн ямар нэгэн гадаад хэлээр хөрвүүлэн орчуулахад агуулгын өнгө аяс, утгын дохио тэмдгийн нарийн ялгамжааг энэхүү толиос үзэж болно.

Дашдондов Ц., Наранхүү Х.
Англи хэлний ижил үгийн
анхны шинэ тайлбар толь / Ред. Б.
Батцэцэг.- УБ.: Мөнхийн үсэг,
2007.- 342 х. – ISBN 99929-147-6 ()

Энэхүү толиос англи хэлний адил дуудлагтай ч ангид өөр утгат үсгээр дагнасан үгсийг харж, судлахад а ш и г л а н а .






Дашдондов Ц.
Монгол англи өвөрмөц хэлц, хэллэгийн толь / Ред. Б. Чулуундорж.- Нэмж, засв. 3 дахь хэвл.- УБ.: Мөнхийн үсэг, 2007.-394 х. – ISBN 99929-5-263-6 ()

Өвөрмөц хэлц, хэллэгүүд нь тухайн ард тзүмний уламжлал аж төрөх ёс, зан заншил, шашин мөргөл, эндэсний сэтгэлгээний онцлогоос шалтгаалан хэл тус бүрт өөр өөр шинжтэй байдаг. Энэхүү толь бичиг нь англи хэл сурч байгаа монгол хүн, монгол хэл сурч байгаа гадаадынханд үнэтэй чухал гарын авлага болно.

Gantsetseg J., Solongo Ch.
English for food science and nutrition / Edi. S. Dugarmaa.-UB., 2007.-205 p. ()

Энэхүү сурах бичигт мэргэжлийн үг хэллэгийг тусгасанаас гадна англи хэлний дүрэм болон унших дасгалуудыг хамруулсан. Хоол боловсруулалт болон биотехнологийн оюутанд зориулагдсан болно.



12-р сард бүрэлдэхүүн салбар сургуулиудаас 70 % -д авсан номын жагсаалт

ААН



Ли Гуан Яо

Буурай орноос бусдын манлайд хүрсэн замнал: 1965-2000 / Орч. Н. Пүрэвдавга; Ред. С. Төгс, Н. Чулуунбаатар.- УБ.: Урлах эрдэм, 2007.- 528 х. – ISBN 978-99929-3-044-6


Сингапурын өнөөгийн тогтвортой байдал, эдийн засгийн өсөлт, хөгжил дэвшил болон Сингапурын тусгаар тогтнолыг Малайзиас хамгаалах, ард иргэдийнхээ амьжиргааг хэрхэн залгуулах арга замыг эрж хайсан амаргүй, урт он жилүүдийг хамарсан үйл явдлын тухай энэхүү ном өгүүлэх б о л н о .

Дугараа П.

Геофизикийн аргын үндэс.-УБ.: МУИС-ийн хэвлэх үйлдвэр, 2007.- 245 х.

Энэхүү номонд дэлхийн чулуулаг бүрхүүлийн гүний тогтцыг судлахад геофизикийн судалгааны аргууд ямар үүрэгтэй ямар үүрэгтэй, нэн тэргүүнд Монгол орны нутаг дэвсгэрийн гүний тогтцын хувьд геофизикийн мэдээллээр мэдэгдэж байгаа судалгааны үр дүнгээс тусгасан. Мөн төрөл бүрийн ашигт малтмалын эрэл хайгуулын ажилд геофизикийн цогцолбор аргуудыг хэрхэн яаж хэрэглэх, ямар үр дүнд хүрэх, тухайн шатанд тавигдсан геологийн даалгаврыг шийдвэрлэхэд ашиглаж байгаа талаар өөрийн орны тодорхой орд газрын бодит жишээнүүдийг тусгажээ





Сүхбаатар Х. ба бус.

**Хэрэглээний цахилгаан техник /
Х. Сүхбаатар, М. Цэрэнбат, Н.
Тавинбэх; Ред. С. Мөнхжаргал.-
УБ.: Их билигт ХХК., 2004.- 390 х.
– 10000 төг .**

Энэхүү номонд цахилгаан эрчим хүчийг дамжуулах ба хэрэглэх, асуудлыг их бүрэн багтаасан бөгөөд цахилгаан дамжуулах ба хуваарилах шугам сүлжээ, трансформатор, хуваарилах байгууламж, цахилгаан машины хийц, тэдгээрийн ашиглалт, засвар үйлчилгээ болон засварын дараах ба өмнөх туршилт хийх аргууд, реле хамгаалалт, автомашины цахилгаан хангамж, хамгаалах аппаратууд, цахилгаан эрчим хүчний хэрэглээний норм, хэмнэх зэргийг тусгасан болно.

Даваасүрэн Н.

**Хими: Сурах бичиг / Ред. М. Юндэн
.-УБ.: Мөнхийн үсэг, 2007.- 529 х. -
ISBN 99929-81-47-4**

Сурах бичигт химийн үндсэн ойлголт ба хуулиуд, Органик биш бодисын ангилал, Д.И. Менделеевийн үелэх систем, химийн холбоо, молекулын бүтэц, комплекс нэгдэл, химийн термодинамик ойлголт, химийн тэнцвэр, уусмалын тухай онол, исэлдэн ангижрах урвал, дисперсийн системийн физик хими, химийн элементүүд, тэдгээрийн химийн нэгдлүүд, коллоид систем зэрэг асуудлуудыг оруулжээ.





Б. Оюунчимэг
Ашигт малтмалын
ордын ашиглалтын үндсэн
параметруудийг оновчлох: Нэг
сэдэвт бүтээл / Ред. Д.
Нармандах.- УБ.: Мастер принт,
2007.-129 х. – ISBN 978-99929-
51-38-9

Энэ номд эрдсийн баялаг ба нөөцийг ангилах, эрдсийн өмчийн үнэлгээ хийхэд цаг хугацааны хүчин зүйлийг харгалздаг динамик аргуудыг хэрэглэх, өнөөгийн цэвэр өртгийн аргаар ашигт малтмалын ордын захын агуулга, нөөцийн хэмжээ, ордын ашиглалтын гүн зэрэг үндсэн параметруудийн оновчлох асуудлыг танин мэдэх геологийн салбарын эдийн засаг судлалын талаар тусгажээ.

Гүндэнсамбуу Ц.
Монголын металлогений
судалгааны асуудалд=
>Вопросы металлогении
Монголии.- УБ., 2007.- 48 х.

Монгол оронд уул уурхайн салбар хөгжиж, шинэ орд илрэлүүд олох шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах асуудлыг шийдвэрлэхэд металлогений анализ, прогноз үнэлгээ зайлшгүй чухал байдаг тул энэхүү номонд металлогении талаар тусгажээ.





Наука и технология:
Учебник русского языка для студентов / Д. Туул, Г. Томтогтох, Г. Туяа, Ц.Тунгалаг; Ред. Т. Батбаяр.-
Испр. и доп. изд.- УБ.: Адмон, 2007.-
195 х. – ISBN 99929-0-308-2
- 4200 төг.

Гадаад хэлний хичээлийн сургалтын агуулгын нэгдүгээр түвшин буюу бакалаврын сургалтаар заавал судлах орос хэлний хичээлийн хөтөлбөрийн дагуу зохиогдсон тул та бүхэн өргөнөөр ашиглах боломжтой.

ÌÒÑ

Түгжсүрэн Н.

Физик экологи: Шуугиан ба доргио / Ред. Ж. Цэвэгмид, Г. Намхайжанцан.-УБ.: Бемби сан, 2006.- 132 х. – ISBN 99929-82-68-3 - 5000 төг .

Номын эхний бүлэгт дуу болоод хэлбэлзэх хөдөлгөөний үүсэх, тарах физик үндэс, хоёрдугаар бүлэгт шуугианы талаарх үндсэн ойлголт, түүний ангилал, биологийн үйлчлэл, норм, үнэлж тодорхойлох арга зүй, хэмжих багажууд, гуравдугаар бүтэгт шуугиан ба доргионоос хамгаалах гол аргууд, дөрөвдүгээр бүлэгт мэдлэг сорих асуултыг хасварган гаргажээ.



Түгжсүрэн Н.

**Агаар мандлын физик:
Д.2: Агаарын мандлын цацрагийн
горим / Д. Ганбаатар, Г. Батсүх.-
УБ.: Бемби сан, 2007.- 149 х. .-
ISBN 99929-82-68-3 - 5300 төг**

Агаар мандлын цацрагийн горим, нарны цацрагийн сулрал, дэлхий ба агаар мандлын цацаргаа, дэлхий ба агаар мандлын цацрагийн тэнцэл гэсэн үндсэн 4 бүлэгтэй. Сурах бичгийн төгсгөлд агаар мандлын физикийн гол тэгшитгэлүүдийг гаргах, бодоход өргөн ашиглагддаг вектор анализын гол тодорхойлолт, томъёонууд, номд орсон үндсэн нэр томъёоны монгол-орос-англи толь, физик гол тогтмолуудын утгыг хавсаргасан болно.



ҮӨӨН



Даваажав Г.

**Монгол хэлний ормол
үгийн толь: Европын хэлнүүдээс
монгол хэлэнд орсон үгс / Ред. Э.
Равдан.- УБ., 2007.- 136 х.**

Энэ тольд ихэвчлэн европын хэлнүүдээс монгол яриа болоод бичгийн хэлэнд орсон үгийг оруулсан. Герег, латин, англи, франц, герман, итали, испани, орос зэрэг 20 орчим хэлний олон салбар ухааны холбогдолтой нэр томъёо, үг хэллэгүүдийг хамруулсан.


Төв номын санд ном хандивлав

МУИС-ийн багш С.Дулам ШУТИС-ийн Төвлөрсөн номын санд өөрийн орчуулсан Францын Пикарди-Жюль Верний Их сургуулийн профессор Жан Копаны бичсэн “Угсаатан судлал, хүн судлалын удиртгал” гэсэн нэртэй номыг 5 ширхэгийг бэлэглэлээ.





ЖАН КОПАН



УГСААТАН СУДЛАЛ,
ХҮН СУДЛАЛЫН
УДИРТГАЛ




**XXI-р зуун “Хөгжлийн клуб”-ын хамт олон
Төв номын санд ном хандивлалаа.**

БНСУ-д суралцаж буй Монгол оюутнуудын санаачилсан **XXI-р зуун “Хөгжлийн клуб”**-ын хамт олон Монголд ажиллаж, суралцаж байгаа анд найз нартаа даяарчлагдаж буй өнөөгийн нийгэмд орчин Үетэйгээ хөл нийлүүлэн алхахад нь нэмэр болоосой гэсэн чин сэтгэлийн Үүднээс манай номын санд мэдээлэл технологи, гадаад хэлний номнуудыг хандивлалаа. Эдгээр номнууд нь манай нийт уншигчдын мэдлэг оюунаа хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж байна. XXI-р зуун “Хөгжлийн клуб”-ын мэдээллийг www.study21c.net хаяг руу орж танилцаж болно.

AutoCAD 2000i
Update







2007 оны номын төвлөрлийн тооцоо

Төвлөрсөн номын сан 2007 онд номын фонд бүрдүүлэхдээ ном бүрдүүлэх журмын дагуу оюутны төлбөрийн 1,5%-тай тэнцэх хөрөнгийг номын сангийн фонд бүрдүүлэлтэнд зориулсан. Үүнээс 30%-ийг Төв номын сангийн фонд бүрдүүлэлтэнд тусгаж төвлөрсөн дансанд шилжүүлж Төв номын сан фондоо бүрдүүлсэн. 70%-ийг сургуулиуд өөрийн төсөвт суулган мэргэжлийн ном, сурах бичиг, гарын авлага авч Төв номын санд нийлүүлсэн. Доорхи хүснэгтэнд 2007 оны номын төвлөрлийн тооцоог гаргав.


/мян.төг/

/2007 оны 12-р сарын 20-ны байдлаар/

№	Номын зардал	Б/АС	ПТС	ХЭС	ХБТС	МаС	МТС	ЭМС
1	Нэмжээгэл авах зардал	18000.0	7400.0	5000.0	8000.0	4250.0	3000.0	19000.0
2	ШУИСийн төвлөрсөн дансанд шилжүүлэх 30%	5400.0	2220.0	1500.0	2400.0	1275.0	900.0	5700.0
3	Сургуулиуд төвлөрсөн дансанд шилжүүлэх 30%ийн бичлэгт	5400.0	2220.0	1500.0	2400.0	1275.0	900.0	5700.0
4	Сургуулиуд н ном, сурах бичиг авах зардал 70%	12600.0	5180.0	3500.0	5600.0	2975.0	2100.0	13300.0
5	Сургуулиуд 70%д ном авсан байдлаар	10115.0	2639.0		3538.5	225.0	1069.7	1782.5
6	Сургуулиуд н 70%ийн үлдэгдэл							

2007 оны номын фонд бүрдүүлэлт

№	Сургуулиуд	Төрөл	Ширхэг	Үнэ /төгрөг/
1	Төв номын сан 30%	158	1651	13080574
2	БИАС 70%	15	526	10115000
3	ХБТС 70%	19	515	3538500
4	ГГТС 70%	23	360	2639000
5	ЭХИС 70%	7	259	1782500
6	МТС 70%	4	159	1069700
7	ХУС 70%	1	100	700000
9	Мат.С 70%	1	30	225000
10	ХБС 70%			
11	ҮТДС	118	1433	8944128
12	КТМС	48	1052	6048900
13	МИС	86	516	3614962
14	ХМТС	104	570	2090895
15	Дарханы ТС.	123	933	6688915
16	Хандив	274	379	4868290
	Нийт	984	8513	65646364



**Оюутны 2-р байранд “Номын өдөрлөг”
зохион байгуулагдав.**

ШУТИС-ийн Төвлөрсөн номын сан, БИАС, Оюутны хөгжлийн төв, оюутны холбоотой хамтарч 2007 оны 12-р сарын 12-нд Оюутны 2-р байранд “Номын өдөрлөг”-ийг зохион байгууллаа. Номын өдөрлөгт Төвлөрсөн номын сангийн захирал Ч. Гультар, БИАС-ийн захирал П. Отгонбаяр, УУИС-ийн захирал Л. Пүрэв, ХУС-ийн дэд захирал Б. Пүрэвсүрэн, Оюутны хөгжлийн төвийн эрхлэгч С. Энхтуяа, бүрэлдэхүүн сургуулиудын ахлах номын санчид, оюутны төлөөлөл оролцлоо. Номын өдөрлөгийн үеэр Төв номын сангаас оюутны 2-р байрны номын санд 52 төрлийн 81 ширхэг 448340 төгрөгний үнэ бүхий эрэлт хэрэгцээ ихтэй ном хандивлав. Мөн БИАС, УУИС, ХУС-ийн захирлууд ном хандивлаж цаашид дэмжиж, хамтран ажиллахаа илэрхийлэв. Энэхүү өдөрлөг нь ШУТИС-ийн оюутны дотуур байрны номын сангийн үйл ажиллагааг сайжруулах, номын фондыг нэмэгдүүлэх зорилгоор зохион байгуулагдаж байгаа ажлын 2 дахь арга хэмжээ юм. Цаашид ХМТС, МИС, КТМС-ийн оюутны дотуур байранд номын өдөрлөгийг зохион байгуулах болно.



**“Монгол Улсын Шинжлэх Ухаан, Технологийн Е- номын сан”
семинар- хэлэлцүүлэг болж өндөрлөлөө.**

Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, БСШУЯ хамтран энэ сарын 18-нд Монгол Улсын Шинжлэх Ухаан, Технологийн Е- номын сан” семинар- хэлэлцүүлэгийг зохион явууллаа. Семинарт Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль, БСШУЯ, Боловсролын хүрээлэн, ШУА-ын хүрээлэн, Америкийн Монгол Судлалын төв, Мэдээллийн Технологийн Үндэсний Парк, Монголын их дээд сургуулиуд, зэрэг 15 гаруй байгууллагын мэдээллийн ажилтнуудыг хамарсан семинар-хэлэлцүүлэг болж өндөрлөлөө. Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн номын санг бүрэн автоматжуулах, е-номын сан байгуулах асуудал, сүлжээнд холбогдсон компьютераас е-номоо унших, зохиогчийн эрхийн асуудлыг хууль эрхзүйн хүрээнд шийдэх, ховор болон ганц хувь номыг е-хэлбэрээр нэгэн зэрэг олон хэрэглэгч унших боломжийг бүрдүүлж байгааг тэмдэглэв.

Тус семинарт Монгол Улсад Шинжлэх Ухаан, Технологийн е-номын сан байгуулах асуудалд, Монгол Улсын е-номын сангийн өнөөгийн байдал, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургуулийн Төвлөрсөн номын сангаас е-номын сан болох нэгдсэн бодлого, хийгдэж буй ажлууд, Е-номын сан, оюуны өмч, Е-номын сангийн програм хангамж, сүлжээ, аюулгүй байдал, зэрэг илтгэлүүд тавигдаж санал солилцсон. Хэлэлцүүлэгээс зөвлөмж гарсныг танилцуулав. Семинарт гадны төлөөлөгчдөөс гадна, мэдээлэл технологи, програм хангамж, компьютерийн чиглэлээр бэлтгэж буй ШУТИС-ийн ХМТС, КМТС, захирал профессорууд маш итэвхитэй оролцов.

Семинарын үеэр гадаад хэл дээрх мэргэжлийн ном, каталоогоор номын үзэсгэлэн гаргасан нь олны талархлыг хүлээв.



ОХУ-ын шинжлэх ухааны е-номын сан

ШУТИС-ийн Төв номын санд электрон уншлагын танхим нээхтэй холбогдуулсан гадаад дотоодын байгууллагуудтай хамтран ажиллах гэрээ хийж байна. ОХУ-ын **шинжлэх ухааны е-номын сангийн** тухай танилцуулж байна. Энэ е-номын сан нь орос улсын шинжлэх ухааны академи, академийн хүрээлэн болон бусад академи, их дээд сургууль, салбарын эрдэм шинжилгээний институт, эрдэм шинжилгээний төв, төрийн байгууллага, томоохон номын сан болон худалдаа эрхэлсэн хэвлэлийн газруудаас нийтлэн гаргадаг шинжлэх ухааны сэтгүүлүүдийг нэгтгэн е-хэлбэрээр нийтийн хүртээл болгож байна. Дээрх е-номын сангийн мэдээллийн санд нийт ОХУ-ын шинжлэх ухааны 500 шахам нэр төрлийн сэтгүүл орос хэл дээр, гадаадын шинжлэх ухааны 6300 гаруй сэтгүүл, 9 сая гаруй өгүүллэг, 1.2 сая гаруй диссертацийн бичлэг хадгалагдаж байна. Орос улсын сэтгүүлийн хэвлэлийн газруудын дотроос хамгийн томоохонд ордог <<Наука>> хэвлэлийн газрын 107 сэтгүүл энэ санд багтаж байна.

Вэб сайт: <http://www.eLIBRARY.RU/>



**ШУТИС-ийн Төв номын сангийн 2008 оны 1-р хагас
жилийн монгол хэвлэл захиалга**

Нэг. Сонин

№	Индекс	Сонины нэр	Гарах дугаар	ширхэг	Үнэ /төгрөг/
1	11324	Ардын эрх	128	1ш	17000
2	10774	Зууны мэдээ	156	1ш	19800
3	11606	Зууны шуудан	156	1ш	19800
4	10757	Монголын мэдээ	128	1ш	12800
5	10816	Өдрийн сонин	156	1ш	19800
6	105181	Өнөөдөр+Ням гариг/ Weekend/	150+26	1ш	32600
7	10003	Улаанбаатар таймс+хүрээ хэмнэл	132	1ш	12000
8	10943	Ардчилал	130	1ш	22000
9	10004	Үнэн	128	1ш	12800
10	10421	Эрүүл мэнд	6	1ш	1800
11	10395	Таван цагираг	50	1ш	11800
12	10459	Сэрүүлэг	24	31 1ш	2007.12 сар №03 8400
13	10012	Утга зохиол үрлэг	18	1ш	6400

Хоёр. Сэтгүүл

№	Индекс	Сэтгүүлийн нэр	Гара дугаар
1.	14288	Билэг	6
2.	14241	Боловсрол судлал	6
3.	14205	Гэгээрэл мэдээлэл	6
4.	14274	Миний компьютер	6
5.	14303	Номын санч	1
6.	14195	Хууль зүйн мэдээлэл	12
7.	14063	Хүн ба хүнс	2
8.	14174	Уул уурхайн сэтгүүл	2
9.	14359	Компьютер таймс	4
10.	14359	Компьютер ба интернет ертөнц	6
11.	14271	Шинжлэх ухаан танин мэдэхүй	6

**ШУТИС-ийн Төв номын сангийн 2008 оны 1-р хагас жилийн
гадаад хэвлэлийн захиалга**

Нэг. Сэтгүүл.

№	Индекс	Сэтгүүлийн нэр	Гарах дугаар	Үнэ / төгрөг /
1	70601	Наука и жизнь	6	67300
2	70328	Здоровье	6	52540
3	70332	Знание сила	6	53850
4	80153	Инновации образования	6	59760
5	71020	Педагогическая информатика мастерская	5	54100
6	73060	Высшее образование в России	6	71100
7	39304	Бурда	6	45500
8	72110	Интерьер дизайн	6	62800
9	80155	Экономика образования	3	36500
10	82950	Вопросы образования	2	35500
11	80531	Мир образование в мире	2	21560
12	73568	Аудит и финансовый анализ CD ROM	2	193000
13	80178	Менеджент в России и за рубежом	3	225000
14	48244	Технологии средства связи	3	82200
15	47343	Broadcasting.		
		Телевидение и радиовещание	4	80500
16	83201	Высшая школа XXI века	1	25500

Төв номын сангийн үйлчилгээ

Төв номын сан 12-р сард үйлчилгээний 7 нэгжээр 14031 уншигчдад 19634 ширхэг номоор үйлчилгээ үзүүлж байна. Номын сангийн үйлчилгээнд анхаарч уншигчдын санал хүсэлтийн дагуу номын фондыг 7 хоногийн 6 өдөр 2 ээлжээр ажиллуулж байна. Доорхи хүснэгтэнд Төв номын сангийн болон бүрэлдэхүүн, салбар сургуулиудын нэгжүүдийн үйлчилгээний байдлыг харуулав.

/2007 оны 11-р сарын 20-ны байдлаар/

1	Í î ï ù í ñàí àèéí í ýæ	- éë÷èè óí ø èã÷è òí î /ç° áó° í ááñáí /
1	- í äñýí ò í ä	7368
	Óí ø èää 3	2608
	Óí ø èää 1	2154
	Óí ø èää 2	1499
	Áääø í àð ÝØ óí ø èää	202
	Òí àòí î è õýæýè	200
	Ò° á í î ï ù í ñàí í è é ò	14031
2	Ê Ò Ì Ñ	800
3	Ì È Ñ	1120
4	- ÒÁÑ	2800
5	Õ Ì ÕÑ	3530
	Í è é ò Ä¿í	22281

Мөн номын эргэлтэнд судалгаа хийхэд дараах чиглэлийн ном хамгийн их үйлчилгээнд гарсан байна. Эхний 20 номыг хэрэглэгдсэн тоогоор гаргав.

/2007 оны 11-р сарын 20-ны байдлаар/

1	Гол зохиолч	Үндсэн гарчиг буюу номын нэр	Хэвлэсэн он	Хэрэглэгдсэн тоо
1	Virginia Evans	Enterprise 2 Elementary: Course and work book	2002	614
2	Evans V.	Enterprise 3 Pre-Intermediate, with workbook	2002	442
3	Тамир Х	Дүрслэх геометр	2007	409
4	Лувсандорж Ш	Монголын түүх	2004	372
5		МТ103 математик III хичээлийн гарын авлага	2005	364
6	Баатарсүх Б	Органик бус хими	2006	344
7	Virginia Evans	Enterprise 1: Beginner, with Workbook	2002	335
8	Дамдинсүрэн Ц	Орос Монгол толь	1982	306
9	Баттогтох Д	Дүрслэх геометрийн лекцүүд "1"	2004	286
10	Дашням М	Ерөний цахилгаан техник	1998	271
11	Базаррагчаа Б	Физик	2002	253
12	Балжинням Л	Физикийн бодлогын хураамж	2002	208
13	Базаррагчаа Б	Физик	2000	205
14	Оухбаатар Г	Дүрслэх геометрийн бодлогын хураамж	2005	199
15	Баатарсүх Б	Хими	1997	191
16	Цэвээнжав Ж	Нэфль, хийн аж үйлдвэрийн үндэс	2003	164
17	Ганболд Д	Философи	2007	164
18	Баасандорж Ж	МТ101 математик 1 хичээлийн семинарын гарын авлага	2004	162
19	Лувсандорж Ш	Монголын түүх	2001	160
20	Оюунгэрэл Ц	Хэрэглээний механик I	2001	154